



КРЕДИТ
ББСБ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 02 сарын 27-ны өдөр

№ 6-1

Улаанбаатар хот

“Хөх тэнгэр” төсөлд хөрөнгө
оруулах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, 76.2, 92 дугаар зүйлийн 92.1 дэх заалт, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн санал хураалтын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн хөрөнгийг нэмэгдүүлэх зорилгоор Хөх тэнгэр төсөлд 9,085,201.12 (Есөн сая наян таван мянга хоёр зуун нэг зуун арван хоёр) ширхэг BS9 токенийг, нэг бүрийг нь 1,856.28 (нэг мянга найман зуун тавин зургаа төгрөг хорин найман мөнгө) төгрөгөөр дундажлан тооцож нийт 16,864,699,403 (арван зургаан тэрбум найман зуун жаран дөрвөн сая зургаан зуун жаран есөн мянга дөрвөн зуун гурав) төгрөгөөр хөрөнгө оруулалт хийх зөвшөөрлийг олгосугай.
2. Хөрөнгө оруулалтын гэрээний нөхцөлийг тогтоолын хавсралтаар баталсугай.
3. Тогтоолын хэрэгжилтийг хангуулж, холбогдох талуудтай хавсралтад заасан нөхцөлөөр гэрээ, хэлцэл байгуулах, компанийг төлөөлөн гэрээ, хэлцэлд гарын үсэг зурах, төлбөр тооцоог хийж гүйцэтгэх эрхийг Гүйцэтгэх захирал (Г.Сүхбаатар)-т олгосугай.
4. Энэхүү санал хураалтад сонирхлын зөрчилгүй этгээдүүд оролцож шийдвэр гаргасан болохыг дурдсугай.
5. Тогтоолын хэрэгжилтийг Төлөөлөн Удирдах Зөвлөлд тайлагнахыг Гүйцэтгэх захирал (Г.Сүхбаатар)-т, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Аудитын Хороо (В.Ганзориг)-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.ГАНЗОРИГ